

0-14 НАСНЫ ХҮҮХДИЙН ДУНД ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТАРХАЛТЫН БАЙДАЛ

Б.Бэрцэцэгмаралмаа¹, Ш.Болд², С.Базаррагчаа²

¹ЭЗШУИС магистрант ²ЭЗШУИС УАУС

bbertsetseg46@gmail.com Утас: 90010114

MAJOR TYPES AND PREVALENCE OF DEVELOPMENTAL DISABILITIES IN CHILDREN AGED 0-14

B.Bertsetsegmaralmaa¹, Sh.Bold², S.S.Bazarragchaa²

¹EZSHUIS undergraduate ²EZSHUIS UAUS

bbertsetseg46@gmail.com, phone number: 90010114

Introduction: Children with disabilities are at greater risk of childhood developmental delays, yet often excluded from the public child development services and programs⁴. The Convention on the Rights of the Child⁵ (UNCRC) and The Convention on the Rights of Persons with Disabilities⁶ (CRPD) points out that children with disabilities have the same rights as every child, such as access to health care, nutrition, education, equal participation in society, and protection from violence and neglect⁷.

Objective: To study the types and prevalence of predominant disabilities of Mongolian in young children

Materials and methods: Predominant types, prevalence and proportion of children with disabilities aged 0-14 years are as of 2019 generated from Report of the National Center for Rehabilitation and Development for period 2017-2020, Report of the National Statistical Office of the disabled for period 2019-2020 and Report for Issues of people with disability: Policies and activities Information directory Center, Ministry of Labor and Social Welfare, for period 2017-2020.

Result and conclusion: As of 2019, there are 8981 (8.4%) children with disabilities aged 0-14 in Mongolia, of which 7075 (78.8%) have congenital disabilities and 1906 (21.2%) have acquired disabilities. By age group, the prevalence of congenital disabilities is 78.2% higher among children aged 0-14. Of these, 1,790 children have lost their ability to function on a daily activity due to a congenital disease, 1474 children with congenital physical disabilities, 1368 children with mental and intellectual disabilities, 749 children with co-morbidities, 741 children with visual impairments, 573 children with speech disabilities and 380 children with hearing impairments.

Key word: children, disabilities, prevalence

Үндэслэл: Хүүхэд ахуй насны үед ямар амьдралын хэв маягтай орчин нөхцөлд өсөж торниж байсан нь хүний насан туршийн амжилт бүтээлд нөлөөлдөг учраас хүүхэд нас бол хүний өсөлт, хөгжлийн маш чухал үе юм¹⁻². Хүүхэд нас бол насан туршийн боловсрол, нийгмийн оролцооны суурийг

нь тавьж өгөх цаг, мөн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээл үүсэхээс сэргийлэх боломж нээлттэй байдаг онцгой чухал “цонх” үе юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд энэ үе нь эцэг эх болон асран хамгаалагчид нь хүүхдийг хөгжүүлэхэд нь тус болох төрөл бүрийн үйлчилгээ, дэмжлэг авч эхлэх чухал үе юм²⁻³.

Хөгжлийн бэрхшээлээс үүдэн хүүхэд нийгмээс тусгаарлагдан ялгаварлан гадуурхагдаж хүүхэд хөгжүүлэх бүх нийтийн үйлчилгээ, хөтөлбөрт хамрагдаж чадахгүй орхигдох эрсдэл их байдаг⁴. Тэдний эрх ашиг, хэрэгцээ шаардлагыг хангасан тусгайлсан буюу зорилгот бүлэгт зориулсан дэмжлэг туслалцаа, үйлчилгээг авч чадахгүй хоцрох нь их байдаг. Хүүхдийн эрхийн тухай конвенц⁵ (ХЭТК), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц⁶ (ХБХЭК) зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхэдтэй адил эрхтэй бөгөөд тухайлбал, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хоол тэжээлээр дутагдахгүй байх, сурч боловсрох, нийгэмд тэгш оролцох, хүчирхийлэл, үл хайхрагдалтаас хамгаалагдах эрхтэй болохыг онцолжээ⁷.

Монгол Улсад 0-14 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2018 оны байдлаар 8981 мянгад хүрч нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.4%-ийг эзэлж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалж, нийгмийн идэвх, оролцоотой насанд хүрсэн хүн болж төлөвшихөд нь туслахын тулд юуны өмнө бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ буюу эрт үеийн хөгжүүлэх үйлчилгээ (Early Childhood Intervention), боловсролын үйлчилгээ зэрэг тусламж дэмжлэгийг хүртээмжтэй болгох, боломжийг судлах зайлшгүй шаардлагаас үүдэн тус сэдвийг сонгон авсан бөгөөд дээр дурдсан (ХБХЭК)-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд улс

орон бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүрч, тэдний оролцоог хангахад тодорхой хүчин чармайлт гаргах хэрэгтэй зэрэг нь бидний судалгааны ажлын үндэслэл болсон.

Зорилго: Монгол Улсын 0-14 насны хүүхдүүдэд зонхилон тохиолдож буй хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, тархалтын байдалд дүн шинжилгээ хийж өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох

Судалгааны арга:

Монгол Улсын 0-14 настай хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийн түгээмэл тохиолдож байгаа хэлбэр, тархалтыг баримт бичгийн магадлан жагсааж, түүвэрлэх аргыг ашиглан тодорхойлно.

Судалгааны хэрэглэгдэхүүн:

- ДЭМБ-ын 2017-2019 оны хөгжлийн бэрхшээлийн тайлан Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн 2017-2020 оны тайлан
- Үндэсний статистикийн хорооны 2019-2020 оны судалгааны ажлын тайлан
- Хөдөлмөр нийгэм хамгааллын яам 2017-2020 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа Мэдээллийн лавлах төвийн тайлан мэдээ

Үр дүн: 2018 оны байдлаар Монгол Улсад нийт 105700 хүн хөгжлийн бэрхшээлтэй байгаагаас эрэгтэй 58700, эмэгтэй 46000 хүн бүртгэгдсэн байгааг дараах зургаар харуулав.




Figure 1. Number and gender of people with disabilities 2013-2018

Зураг 1-ээс үзэхэд 2013-2018 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 9400 -аар буюу (8.8%) -аар өссөн үзүүлэлттэй байна. 0-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дунд тохиолдож буй шалтгааныг доорх зургаар харуулав.




Figure 2. Type of disability (0-14 age)

Зураг 2-оос үзэхэд 0-14 насны нийт 8981 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 7075 (78.8%), олдмол хөгжлийн бэрхшээлтэй 1906 (21.2%)- ийг эзэлж байгаа нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь 3.7 дахин их байна.

0-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр ангилсан байдлыг дараах хүснэгтээр харуулав.

Table 1. Disability indicators for children aged 0-14

Age	Type of disability		
	All	Congenital	Acquired
0-4	1997	1679	318
5-9	3542	2813	729
10-14	3442	2583	859
Total	8981	7075	1906

Хүснэгт 1-ээс үзэхэд 0-4 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 1997 (22.2%) байгаагаас төрөлхийн 1679 (84%), олдмол 318 (16%), 5-9 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 3542 (39.4%) байгаагаас төрөлхийн 2813 (79.4%), олдмол 729 (20.6%), 10-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 3442 (38.3%) байгаагаас төрөлхийн 2583 (75%), олдмол 859 (24.9%)-д илэрсэн байна.

10-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 3442 (38.3%) байгаагаас төрөлхийн 2583 (75%), олдмол ХБ 859 (24.9%)-д илэрсэн байна. 0-4 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн шалтгаан нь жирэмсний болон төрөх үед илэрсэн хүчин зүйлсээс, 5-14 насны хөгжлийн бэрхшээлийн шалтгаан нь хожуу үед илэрсэн удамшлын өвчинтэй холбоотой байна.

0-14 настай харааны хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгаанаар үзүүлсэн дүнг дараах хүснэгтээр харуулав.

Table 2. Number of visually impaired children aged 0-14

	Visual impairments						
	All	Congen- ital	Acquired	Type of disability			
				Disease		Accident and injuries	
				General illness	Professional reason	Traffic accident	Domestic accident
0-4	183	153	30	27	0	0	3
5-9	357	292	65	58	0	1	6
1014	408	296	112	88	1	4	19
Total	948	741	207	173	1	5	28

Хүснэгт 2-оос харахад 0-14 насны харааны бэрхшээлтэй хүүхэд 948 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 10.5% -ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн харааны бэрхшээлтэй 741 (8.2%), олдмол харааны бэрхшээлтэй 207 (2.3%) хүүхэд байна.

Харааны хөгжлийн бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 183 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 153 (83.6%), олдмол шалтгаантай 30 (16.3%) хүүхэд байна. Үүнээс 27 (14.7%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 3 (1.6%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Харааны хөгжлийн бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 357 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 292 (81.8%), олдмол шалтгаантай 65 (18.2%) хүүхэд байна. Үүнээс 58 (16.2%)

хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 1 (0.2%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 6 (1.6%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Харааны хөгжлийн бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд 408 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4.5%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 296 (72.5%), олдмол шалтгаантай 112 (27.5%) хүүхэд байна. Үүнээс 88 (21.5%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 1 (0.2%) хүүхэд ажил хөдөлмөр эрхлэлтийн улмаас, 28 (6.8%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 6 (1.6%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

0-14 настай ярианы бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгааныг дараах хүснэгтээр үзүүллээ.

Table 3. Number of children with speech disabilities aged 0-14

	Speech disabilities						
	All	Congen- ital	Acquired	Type of disability			
				Disease		Accident and injuries	
				General illness	Professional reason	Traffic acci- dent	Domestic acci- dent
0-4	106	98	8	8	0	0	0

5-9	260	227	33	29	0	0	4
1014	303	248	55	50	0	3	2
Total	669	573	96	87	0	3	6

Хүснэгт 3-аас үзэхэд 0-14 насны ярианы бэрхшээлтэй хүүхэд 669 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 7.5%-ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн ярианы бэрхшээлтэй 573 (6.3%), олдмол ярианы бэрхшээлтэй 96 (1%) хүүхэд байна.

Ярианы бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 106 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1.2%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 98 (92.5%), олдмол шалтгаантай 8 (7.5%) хүүхэд байна. Үүнээс 8 (7.5%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Ярианы бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 260 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2.8%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 227 (87.4%), олдмол шалтгаантай 33 (12.6%) хүүхэд байна. Үүнээс

29 (11.1%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 4 (1.5%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Ярианы бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд 303 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 3.3%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 248 (81.8%), олдмол шалтгаантай 55 (18.1%) хүүхэд байна. Үүнээс 50 (16.5%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 3 (0.9%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 2 (0.6%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

0-14 настай сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгааныг дараах хүснэгтээр үзүүлээ.

Table 4. Number of children with hearing impairments aged 0-14

	Hearing impairments						
	All	Type of disability		Disease			
		Congenital	Acquired	Disease		Accident and injuries	
				General illness	Professional reason	Traffic accident	Domestic accident
0-4	78	70	8	8	0	0	0
5-9	169	139	30	26	0	2	2
10-14	209	171	38	29	1	2	5
Total	456	380	76	63	1	3	7

Хүснэгт 4-өөс харахад 0-14 насны сонсголын бэрхшээлтэй хүүхэд 456 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 5%-ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн сонсголын бэрхшээлтэй 380 (4.2%), олдмол сонсголын бэрхшээлтэй 76 (0.8%) хүүхэд байна.

Сонсголын бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 78 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 0.9%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 70 (89.7%) олдмол шалтгаантай 8 (10.3%) хүүхэд байна. Үүнээс 8 (10.3%) хүүхдийн хөгжлийн

бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна

Сонсголын бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 169 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1.8%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 139 (82.2%) олдмол шалтгаантай 30 (17.7%) хүүхэд байна. Үүнээс 26 (15.3%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 2 (1.1%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 2 (1.1%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Сонсголын бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд 209 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийн 2.3%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 171 (81.8%) олдмол шалтгаантай 38 (18.1%) хүүхэд байна. Үүнээс 29 (13.8%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 1 (0.2%) хүүхэд ажил хөдөлмөр эрхлэлтийн улмаас, 2 (0.9%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 5 (2.3%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

0-14 настай хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгааныг дараах хүснэгтээр үзүүлээ.

Table 5. Number of children with physical disabilities aged 0-14

	Physical disability						
	All	Type of disability		Accident and injuries			
		Congenital	Acquired	Disease		Traffic accident	Domestic accident
			General illness	Professional reason			
0-4	423	357	66	50	0	5	11
5-9	750	599	151	103	0	18	28
10-14	693	518	175	136	0	15	23
Total	1866	1474	392	289	0	38	42

Хүснэгт 5-аас үзэхэд 0-14 насны хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд 1866 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 20.8% -ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн хөдөлгөөний бэрхшээлтэй 1474 (16.4%), олдмол сонсголын бэрхшээлтэй 392 (4.4%) хүүхэд байна.

Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 423 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4.7%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 357 (84.4%) олдмол шалтгаантай 66 (15.6%) хүүхэд байна. Үүнээс 50 (11.8%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 5 (1.6%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 11 (2.6%) хүүхэд

ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 750 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 8.3%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 599 (79.8%) олдмол шалтгаантай 151 (20.2%) хүүхэд байна. Үүнээс 103 (13.7%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 18 (2.4%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 28 (3.7%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд 693 буюу нийт хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдийн 7.7%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 518 (74.7%) олдмол шалтгаантай 175 (25.3%) хүүхэд байна. Үүнээс 136 (19.6%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 15 (2.1%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 23 (3.3%) хүүхэд

ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

0-14 настай Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгааныг дараах хүснэгтээр үзүүлээ.

Table 6. Number of children with mental and intellectual disabilities aged 0-14

Mental and intellectual disabilities							
All	Type of disability						
	Congenital	Acquired	Disease			Accident and injuries	
			General illness	Professional reason	Traffic accident	Domestic accident	
0-4	279	260	19	19	0	0	0
5-9	613	532	81	74	0	1	5
10-14	679	576	103	89	0	7	7
Total	1571	1368	203	182	0	8	12

Хүснэгт 6-аас харахад 0-14 насны оюуны бэрхшээлтэй хүүхэд 1571 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 17.5% -ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн оюуны бэрхшээлтэй 1368 (15.4%), олдмол сонсголын бэрхшээлтэй 203 (2.3%) хүүхэд байна.

Оюуны бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 279 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 3.1%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 260 (93.2%) олдмол шалтгаантай 19 (6.8%) хүүхэд байна. Үүнээс 19 (6.8%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Оюуны бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 613 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 6.8%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 532 (86.7%) олдмол шалтгаантай 81 (13.2%) хүүхэд байна. Үүнээс 74 (12%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 1 (0.1%) хүүхэд

зам тээврийн ослын улмаас, 5 (0.8%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Оюуны бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд 679 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 7.6%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 576 (84.8%) олдмол шалтгаантай 103 (15.2%) хүүхэд байна. Үүнээс 89 (13.1%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, (1%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 7 (1%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

0-14 настай хавсарсан бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгааныг дараах хүснэгтээр үзүүлээ.

Table 7. Number of children with co-morbidities aged 0-14

	Co-morbidities						
	All	Congenital	Acquired	Type of disability			
				Disease		Accident and injuries	
			General illness	Professional reason	Traffic accident	Domestic accident	
0-4	214	184	30	25	0	0	5
5-9	359	301	58	45	1	2	8
10-14	361	264	97	85	0	2	8
Total	934	749	185	155	1	4	21

Хүснэгт 7-оос харахад 0-14 насны хавсарсан бэрхшээлтэй хүүхэд 934 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 10.4% -ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн хавсарсан бэрхшээлтэй 749 (8.3%), олдмол сонсголын бэрхшээлтэй 185 (2.1%) хүүхэд байна.

Хавсарсан бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 214 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2.3%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 184 (85.9%) олдмол шалтгаантай 30 (14.1%) хүүхэд байна. Үүнээс 25 (11.6%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 5 (2.3%) нь ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хавсарсан бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 359 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 301 (83.8%) олдмол шалтгаантай 58 (16.2%) хүүхэд байна. Үүнээс 45 (12.5%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 1 (0.2%) хүүхэд ажил хөдөлмөр эрхлэлтийн улмаас, 2 (0.5%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 8 (2.2%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хавсарсан бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд 361 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4%-ийг эзэлж байна. Төрөлхийн

шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 264 (73.1%) олдмол шалтгаантай 97 (26.8%) хүүхэд байна. Үүнээс 85 (23.5%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 2 (0.5%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 8 (2.2%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

0-14 настай бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, насны ангилал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, шалтгааныг дараах хүснэгтээр үзүүлээ.

Table 8. Number of children with other disabilities aged 0-14

	Other disabilities						
	All	Congenital	Acquired	Type of disability			Domestic accident
				General illness	Disease	Accident and injuries	
				Professional reason	Traffic accident		
0-4	714	557	157	133	2	4	15
5-9	1034	723	311	265	5	12	27
10-14	789	510	279	237	2	9	30
Total	2537	1790	747	635	9	23	72

Хүснэгт 8-аас харахад 0-14 насны бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2537 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 28.2%-ийг эзэлж байна. Үүнээс төрөлхийн бусад хөгжлийн бэрхшээлтэй 1790 (19.9%), олдмол бусад хөгжлийн бэрхшээлтэй 747 (8.3%) хүүхэд байна.

Бусад бэрхшээлтэй 0-4 насны хүүхэд 714 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 7.9%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 557 (78%) олдмол шалтгаантай 157 (21.9%) хүүхэд байна. Үүнээс 133 (18.6%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 2 (0.2%) хүүхэд ажил хөдөлмөр эрхлэлтийн улмаас, 4 (0.5%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 15 (2.1%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Бусад бэрхшээлтэй 5-9 насны хүүхэд 1034 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 11.5%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 723 (69.9%) олдмол шалтгаантай 311 (30%) хүүхэд байна. Үүнээс 265 (25.6%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 5 (0.4%) хүүхэд ажил хөдөлмөр эрхлэлтийн улмаас, 12 (1.1%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 27 (2.6%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Бусад бэрхшээлтэй 10-14 насны хүүхэд

789 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 8.7%-ийг эзэлж байна. Төрөлхийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй 510 (64.6%) олдмол шалтгаантай 279 (35.3%) хүүхэд байна. Үүнээс 237 (30%) хүүхдийн хөгжлийн бэрхшээл үүсгэх хүчин зүйл нь өвчний улмаас, 2 (0.2%) хүүхэд ажил хөдөлмөр эрхлэлтийн улмаас, 9 (1.1%) хүүхэд зам тээврийн ослын улмаас, 30 (3.8%) хүүхэд ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Дүгнэлт : 2019 оны байдлаар Монгол Улсад 0-14 насны хөгжлийн бэрхшээлтэй 8981 (8.4%) хүүхэд байгаагаас төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 7075 мянга буюу 78.8%, олдмол хөгжлийн бэрхшээлтэй 1906 мянга буюу 21.2%-ийг эзэлж байна. Энэхүү үзүүлэлтийг насны бүлгээр ангилахад бага 0-14 насны хүүхдүүд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол олдмол хөгжлийн бэрхшээлээс 78.2%-аар илүү байгаа нь ажиглагдаж байна. Үүнээс төрөлхийн ямар нэгэн өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагаа, гүйцэтгэх чадвараа алдсан бэрхшээлтэй 1790 хүүхэд, төрөлхийн хөдөлгөөний бэрхшээлтэй 1474 хүүхэд, сэтгэц оюуны бэрхшээлтэй 1368, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 749, харааны бэрхшээлтэй 741, хэл ярианы бэрхшээлтэй 573, сонсголын бэрхшээлтэй 380 хүүхэд байна.

Хэлцэмж: Дэлхий дахинд одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн

тоог бодитойгоор гаргасан баталгаатай, найдвартай эх сурвалж байхгүй байна. Хүүхэд насанд тохиолдож буй хөгжлийн бэрхшээлийн тухайд хоорондоо хол зөрөөтэй тооцоо гарч байгаа нь судалгаанд ялгаатай тодорхойлолт, олон янзын аргачлал, хэрэглэгдэхүүн ашиглаж байгаатай холбоотой ажээ⁴⁻¹¹. Хүн амын тооллого, өрхийн судалгааны аргачлалаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх боломжгүй, бага, дунд орлоготой ихэнх улс (БДОУ)-д бүртгэлийн найдвартай систем байхгүй, соёлын онцлогийг харгалзсан оношилгоо, эмчилгээ хүртээмжгүй байгаа зэргээс болж хөгжлийн бэрхшээл дутуу бүртгэгдэж байх бүрэн магадлалтай⁴. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдийг олж илрүүлээгүй, шаардлагатай үйлчилгээнд хамруулаагүй байх магадлалтай⁵ гэж ДЭМБ-ийн байгууллагаас жил бүр гаргадаг тайландаа дурджээ.

Швейцарын судлаач Maulik РК бага, дунд орлоготой 41 улс орнуудын хүүхдийн хөгжлийн бэрхшээл: урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ, хууль тогтоомж, тархвар судлалын тойм судалгааг хийж энэхүү дүгнэлтэд хүрсэн мэдлэг, ялангуяа хөндлөнгийн оролцоо, үйлчилгээний ашиглалт, хууль тогтоомжийн зөрүү олж тогтоосон. Эпидемиологийн судалгаа хүртэл чанарын хувьд хангалтгүй байсан бөгөөд сонсгол, оюуны хөгжлийн бэрхшээлээс бусад нөхцөлд судалгаа дутмаг байв. Ирээдүйн судлаачид өнөөгийн мэдлэгийн эдгээр цоорхойг арилгахаас гадна бага, дунд орлоготой орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдралд нөлөөлөх нийгмийн эрүүл мэндийн бодлогын өөрчлөлтөд өөрсдийн судалгааг хөрвүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй⁹.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон амьжиргааны төвшин тогтоох судалгаа байгаа боловч ХБ хүүхдийн талаарх судалгаа хомс байдаг нь хүүхдийн хөгжлийн

хоцрогдлыг урьдчилан сэргийлэх, шинээр бий болж байгаа ур чадваруудыг өдөөж хөгжүүлэх, хүүхдийг дэмжиж, хамгаалахад илүүтэй анхаарсан орчин, нөхцөл бий болгох нэмэлт үйлчилгээнүүдийг гэр бүл, эцэг эхийн тусламжтайгаар аль болох эрт эхлүүлэхэд суурь судалгаа зайлшгүй хэрэгтэй байна¹¹.

Ном зүй:

1. Status of the Convention on the Rights of the Child: report of the Secretary-General. In: Sixty-fifth General Assembly of the United Nations, New York, 2 August 2010. New York, United Nations,
2. Early childhood development: a powerful equalizer. Geneva, World Health Organization, 2007 (http://www.who.int/social_determinants/resources/ecd_kn_report_07_2007.pdf, accessed 25 January 2012).
3. UNESCO Policy Brief on Early Childhood. Inclusion of Children with Disabilities: The Early Childhood Imperative. N°46 / April – June 2009 /REV/. (<http://unesdoc.unesco.org/images/0018/001831/183156e.pdf>, accessed 25 January 2012).
4. Simeonsson RJ. Early childhood development and children with disabilities in developing countries. Chapel Hill, University of North Carolina, 2000
5. World Health Organization, World Bank. World report on disability. Geneva, World Health Organization, 2011 (http://www.who.int/disabilities/world_report/2011/en/index.html, accessed 25 January 2012).
6. Convention on the Rights of the Child. New York, United Nations, 1989.
7. Convention on the Rights of Persons with Disabilities. New York, United Nations, 2006.

8. International classification of functioning, disability and health: children and youth version. Geneva, World Health Organization, 2007.
9. Maulik PK, Darmstadt GL. Childhood disability in low-and middle-income countries: overview of screening, prevention, services, legislation and epidemiology. Lancet, 2007, 120:S1-S55.
10. Monitoring disability in developing countries: results from the multiple cluster survey. New York, United Nations Children's Fund and University of Wisconsin, 2008. (<http://www.crin.org/resources/infodetail.asp?id=19377>, accessed 25 January 2012).
11. Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл Асуудал дэвшүүлсэн тайлан: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2012 он. https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, дэд професор Л.Уламбаяр*